

Шинэ төрлийн коронавирусын эсрэг вакцин хийлгэх хүсэлтэй гадаад иргэдэд

Коронавирусын эсрэг вакцины купон ирнэ!

Анхаарал!

- Шинэ төрлийн “коронавирусын эсрэг вакцины купон” болон “вакцины мэдэгдэл” -ийг хот, дүүргийн захиргаанаас дэс дараатайгаар явуулж байна. (“вакцины мэдэгдэл”- ийн загварыг тусад нь хавсаргасан болно.)
- Та оршин суугчийн үнэмлэх дээрх хаягаасаа өөр газарт оршин сууж байгаа бол купон нь ирэхгүй тул аль болох эртхэн хот, дүүргийн захиргаандаа хандан өөрийн хаягаа бүртгүүлнэ үү.

① Хот, дүүргийн захиргаанаас дугтуй ирэх ба түүнд “コロナ(корона)” эсвэл “ワクチン(вакцин)” гэж бичсэн байвал агуулгыг нь шалгана уу.



② Шинэ төрлийн коронавирусын эсрэг вакцины купоныг дэс дараатайгаар илгээж байна. Купоны дарааллын тухай мэдээллийг хот, суурин газрынхаа мэдэгдлээс (цахим хуудас гэх мэт) үзнэ үү.

③ Оршин суугчийн үнэмлэх дээрх хаягаас өөр газарт оршин сууж байгаа бол хотын захиргаандаа хандан хаягаа бүртгүүлнэ үү.

④ Шинэ төрлийн коронавирусын эсрэг вакцины купоноо хүлээн авбал “вакцины мэдэгдэл”-д заасны дагуу захиалга өгч, вакцинаа хийлгэнэ үү. Асуулт байвал дараагийн нүүрийн (1)-ээс (4)-д холбогдон асууна уу.



**Хилийн шалган нэвтрүүлэх,
оршин суух хяналтын газар**
Гадаадын оршин суугчдыг дэмжих төв

外国人在留支援センター
FRESA

Шинэ төрлийн коронавирусын эсрэг вакцины купон хүлээн авсны дараа асуух зүйл байвал (1)-ээс (4)-ийн аль нэгэнд холбогдоно уу.

(1) Оршин суугаа хот, суурин газар

Дугтуй дээр бичгдсэн утас руу холбогдоно уу.

(2) Эрүүл Мэнд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамны шинэ төрлийн коронавирусын эсрэг вакцины лавлах төв

Утас: 0120-761-770 (Үнэ төлбөргүй утас)

Ажлын цаг: 9:00 - 21:00 (Бямба, Ням гариг болон бүх нийтийн амралтын өдрүүдэд ч мөн ажиллана)

Үйлчлэх хэлнүүд: Япон, англи, хятад, солонгос, португаль, испани хэл 9:00 - 21:00

Тайланд хэл 9:00 - 18:00

Вьетнам хэл 10:00 - 19:00

(Лавлагаа) Вакцинаас бусад шинэ төрлийн коронавируст халдварын тухай Эрүүл Мэнд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамны лавлах төв

- Шинэ төрлийн коронавируст халдварын тухай Эрүүл Мэнд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамны лавлах төв

Утас: 0120-565-653 (Үнэ төлбөргүй утас)

Ажлын цаг: 9:00 - 21:00 (Бямба, Ням гариг болон бүх нийтийн амралтын өдрүүдэд ч мөн ажиллана)

Үйлчлэх хэлнүүд: Япон, англи, хятад, солонгос, португаль,

испани хэл 9:00 - 21:00

Тайланд хэл 9:00 - 18:00

Вьетнам хэл 10:00 - 19:00

(3) Гадаадын оршин суугчдыг дэмжих төв FRESO тусламж

Утас: 0120-76-2029 (Үнэ төлбөргүй утас)

Ажлын цаг: 9:00 - 17:00 (Зөвхөн ажлын өдрүүдэд ажиллана)

Үйлчлэх хэлнүүд: Япон, англи, хятад, солонгос, португаль, испани, тайланд, вьетнам, филиппин, кхмер, балба, индонез, мьянмар, монгол, франц, синхал, урду, бенгал хэл

(4) Орон нутгийн лавлах (Гадаад иргэдийн ахуй амьдралд туслах портал сайт)

• Япон хэл <https://www.moj.go.jp/isa/content/930004512.pdf>

• Англи хэл <https://www.moj.go.jp/isa/content/930005173.pdf>



* Үйлчлэх боломжтой гадаад хэлний төрөл нь лавлах газар бүрд өөр байх болно.



Коронавирусын эсрэг вакцины вэбсайтаар зочлоорой.

"Коронавирусын эсрэг вакцины вэбсайтын" хаяг: <https://v-sys.mhlw.go.jp>

* Хэрэв та эмнэлгийн байгууллага эсвэл вакцин хийлгэх газар олохгүй бол харьяа хотын захиргаанд хандана уу.

* Коронавирусын эсрэг вакцины вэбсайтаас шууд захиалга өгөх боломжгүй.



Энэ нь Эрүүл Мэнд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамнаас гаргасан загвар юм.

Таны амьдарч буй харьяа хот, дүүргээс гаргасан мэдэгдлийн агуулгаас өөр байх боломжтой.

Хотын захиргааны нэр

Коронавирусын эсрэг вакцины мэдэгдэл

Үнэ төлбөргүй
вакцинжуулалт
(Засгийн газраас
бүрэн санхүүжүүлнэ)



Вакцинжуулалтын явц

1 Вакцинаа хэзээ хийлгэж болохыг тэмдэглэнэ

Коронавирусын эсрэг вакциныг **эмнэлгийн ажилчид, ахмад настан, хавсарсан өвчтэй хүмүүсээс** эхлэн дарааллаараа хийлгэнэ. Вакцин хийлгэх захиалгаа баталгаажуулж, өөрийн ээлжээ хүлээнэ үү.

*Засгийн газрын мэдэгдлийг хүлээнэ үү. Та мөн Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны вэбсайт эсвэл хотын захиргааныхаа зөвлөгөө өгөх цэгт хандаж болно.

*Арын нүүрэн дээрх мэдээлэл нь ахмад настан, эрүүл мэндийн суурь өвчтэй хүмүүст хамаатай.

*Хэдийгээр та хэсэг хугацаа хүлээх шаардлагатай байж магадгүй ч вакцин хийлгэхийг хүссэн хүн бүхэн вакцинаа цаг тухайд нь хийлгэх боломжтой тул тэвчээртэй байхыг сануулья.

2 Эмнэлэг эсвэл вакцин хийлгэх газрыг олох

Та вакцинаа хийлгэх боломжтой эмнэлэг эсвэл вакцин хийлгэх газрыг хот, суурин газрынхаа олон нийтэд зориулсан сэтгүүлээс эсвэл интернетээс олж болно.

Коронавирусын эсрэг вакцины талаархи ерөнхий мэдээллийн вэбсайтаас баруун талд байрлах кодоор дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой.

Коронавирусын эсрэг вакцины вэбсайтын хаяг: <https://v-sys.mhlw.go.jp>

*Хэрэв та эмнэлгийн байгууллага эсвэл вакцин хийлгэх газар олохгүй бол харьяа хотын захиргаанд хандаж болно.

*Вакциныг эмнэлэгт хэвтэж эмчлүүлээгүй л бол оршин суух газраа бүртгүүлсэн хот, тосгонд хийх ёстой. Бүртгэгдсэн хаягаас гадна вакцин тарих талаар хуудасны арын хэсгээс үзнэ үү.

*Коронавирусын эсрэг вакцины вэбсайтаар дамжуулан шууд захиалах боломжгүй юм.



Коронавирусын эсрэг вакцины хоёрдогч код

3 Захиалга өгөөд вакцинаа хийлгээрэй

Вакцин хийлгэхийг хүсч буй эрүүл мэндийн байгууллага эсвэл хотын захиргаатай холбоо бариарай.

Танай бүсэд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд

Эмнэлгийн байгууллагад шууд цаг авах (утас, интернетээр дамжуулан) г.м


Хот суурин газрын вакцинжуулалтын газар

Дуудлагын төв:



Юу авч очих вэ?

- Купон (энэ мэдэгдэлд хавсаргасан)
- Иргэний үнэмлэх (жолооны үнэмлэх, эрүүл мэндийн даатгалын дэвтэр гэх мэт)



*Вакцин хийлгэхээс өмнө биеийнхээ температурыг гэртээ хэмжээрэй. Халуурах шинж тэмдэг илэрсэн эсвэл бие тавгүйрхвэл цаг товлосон хотын захиргаа, эрүүл мэндийн байгууллагатай холбоо барьж вакцин хийлгэхээс татгалзаарай.

*Мөрөө ил гаргахад илүү хялбар хувцас өмснө үү.

*Вакциныг бүрэн үр дүнтэй болгохын тулд заагдсан интервалаар нэг төрлийн вакциныг хоёр тунгаар хийх шаардлагатай. Эхний тунг хийсний дараа дараагийн шатны вакцин хийлгэх хугацааг шалгана үү.

*Хавсаргасан купонууд нь вакцин эсвэл вакцинжуулалтын хоёр гэрчилгээнд зориулагдсан болно. Хийлгэх болгонд тус маягыг авчирна, тасалж болохгүй.

Энэ нь Эрүүл Мэнд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамнаас гаргасан загвар юм.

Таны амьдарч буй харьяа хот, дүүргээс гаргасан мэдэгдлийн агуулгаас өөр байх боломжтой.

© **Ахмад настнуудад вакцинжуулалтыг эхлүүлэх**

Эхлээд санхүүгийн 2021 онд 65 нас хүрсэн хүмүүсийг (1957 оны 4-р сарын 1-нд төрсөн хүмүүс эсвэл үүнээс өмнө) вакцинжуулахаар төлөвлөж байгаа боловч энэ хугацааг хувааж болно.

© **Хавсарсан өвчтэй хүмүүсийн тухайд яах вэ?**

Хавсарсан өвчтэй хүмүүсийг вакцинжуулах ажлыг өндөр настай хүмүүст вакцин хийсний дараа хийнэ. Эрүүл мэндийн суурь өвчтэй хүмүүс нь дараах шалгуурт багтсан хүмүүс юм (2021 оны 2-р сарын 1-ний байдлаар; өөрчлөгдөж болно).

1. Амбулаториор болон хэвтэн эмчлүүлж буй дараах өвчнөөр өвчилсөн хүмүүс

- | | |
|---|---|
| 1. Амьсгалын замын архаг өвчин | 9. Дархлалын эмгэгтэй холбоотой мэдрэлийн ба мэдрэл булчингийн өвчин |
| 2. Зүрхний архаг өвчин (гипертони орно) | 10. Мэдрэлийн эсвэл мэдрэл булчингийн өвчнөөс (амьсгалын замын эмгэгийг оруулаад) бие махбодийн үйл ажиллагаа буурсан |
| 3. Бөөрний архаг өвчин | 11. Хромосомын эмгэг |
| 4. Элэгний архаг өвчин (элэгний хатуурал ба үүнтэй төстэй өвчин эмгэг) | 12. Сэтгэцийн болон бие махбодийн хүнд хэлбэрийн согог (бие махбодийн хүнд хэлбэрийн доройтол ба оюуны хүчтэй эмгэг) |
| 5. Инсулин эсвэл эмээр эмчилсдэг чихрийн шижин, эсвэл бусад өвчний улмаас үүсэн чихрийн шижин | 13. Унтах үеийн апоноэ хам шинж |
| 6. Цусны өвчин (төмрийн дутагдлын цус багадалтыг эс тооцно) | |
| 7. Дархлалын тогтолцооны үйл ажиллагаанд саад учруулж буй өвчнүүд (үүнд тухайн хүний эмчлэгдэж буй хорт хавдар) | |
| 8. Дархлаа, түүний дотор стероидыг дарангуйлдаг эмчилгээ | |

2. Хэт таргалалттай хүмүүс (БЖИ 30 ба түүнээс дээш)

БЖИ = биеийн жин (кг) ÷ өндөр (м) ÷ өндөр (м)
*БЖИ-ийн удирдамж - 30: өндөр - 170 см, жин - 87 кг; өндөр - 160 см, жин - 77 кг

Үүний зэрэгцээ ахмад настны асрамжийн газарт ажилладаг байгууллагын ажилтнуудад вакцинжуулалт хийнэ.

© **Оршин суугчийн үнэмлэх (оршин суух газар) -ын дагуу бүртгэлтэй газраас бусад газарт вакцин хийлгэх**

• Хэрэв та вакцинаа эрүүл мэндийн байгууллага эсвэл таны эмчлүүлж байгаа байранд хийлгэвэл тухайн эрүүл мэндийн байгууллагаас зөвлөгөө аваарай.

• Хэрэв та суурь өвчний улмаас эмчлүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагад вакцин хийлгэвэл тухайн эрүүл мэндийн байгууллагаас зөвлөгөө аваарай.

• Хэрэв таны оршин сууж буй газар таны үндсэн хаягаас өөр бол та вакцинаа амьдардаг газартаа хийлгэж болно.

Коронавирусын эсрэг вакцины талаархи вэбсайтыг шалгах эсвэл таны амьдардаг хотын захиргааны зөвлөх албатай холбоо бариарай.

© **Вакцинжуулалтад хамрагдахын тулд таны зөвшөөрөл шаардлагатай**

Хэрэв та одоо эрүүл мэндийн шалтгаанаар эмчилгээ хийлгэж байгаа эсвэл эрүүл мэнддээ санаа зовж байгаа бол вакцин хийлгэх эсэхээ шийдэхийн өмнө хариуцсан эмчтэйгээ зөвлөлдөөрэй.

Коронавирусын эсрэг вакцины үр нөлөө, аюулгүй байдлын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг Японы Ерөнхий сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын вэбсайтад дахь Шинэ төрлийн коронавирусын вакцин хуудаснаас үзнэ үү.

Японы Ерөнхий сайд, Сайд нарын танхим, коронавирусын эсрэг шинэ вакцин

Хайх



Хэрэв та вэбсайтаа үзэх боломжгүй бол хотын захиргаатай холбоо бариарай.